



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2009 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Нэрийн дансны 2008 оны орлогод тооцох хүүгийн
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2008 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 18,7 хувиар баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолоор батлагдсан хүүгийн хэмжээг баримтлан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2008 оны орлогод хүү тооцох арга хэмжээг 2009 оны 2 дугаар улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар (Ч. Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын алба (М. Батаа)-нд даалгасугай.



Д. НЯМХҮҮ